

ГҮЙФАН 鬼方, СЯНЬЮНЬ 玁狁 БА БАРУУН ЖОУ

П.ДЭЛГЭРЖАРГАЛ

Товч агуулга: Цинь, Хань улсаас өмнөх үеийн хятадын сонгодог сурвалжууд болох “Хулсан номын тэмдэглэл” (竹書紀年zhushu jinian), “Зо Жуань” (左傳 zuo zhuan), “Шүлгэлсэн ном” (詩經shijing), “Улсын өгүүлэл” (國語 guo yu) зэрэг сурвалж бичигт гүйфан, сяньюнь, жун (цуаньжун, баруун жун, уулын жун), ди (улаан ди, цагаан ди, умард ди) зэрэг умардын ард түмнүүдийн талаарх мэдээ маш товч байдаг. Харин Баруун Жоугийн үед холбогдох Сяо Үй дин (小孟鼎 xiao yu ding), Дүо Ю дин (多友鼎 duo you ding), Гози Зибай пан (號季子白盤 Guo jili baipan), Бүцигүй (不其簋buqigui) хүрэл сав (хүлс)-ны бичээсэнд гүйфан, сяньюнь, жун (цуаньжун, баруун жун) нартай хийсэн байлдааны талаар дэлгэрэнгүй өгүүлж байна. Эдгээр хүрэл савны бичээсүүд нь Дотоод Азийн эртний нүүдэлчид НТӨ X-IX зууны үед тэрэгт цэрэг хэрэглэн дайтаж байсныг нотолж байгаа төдийгүй гүйфан, сяньюнь, жун нарын талаарх олон асуудлыг тодруулах боломж олгож байна.

Түлхүүр үг: гүйфан, сяньюнь, жун, байлдааны тэрэг.

Неолитын үеэс хятадын соёлоос эрс ялгагдах өөрийн онцлогтой соёл Дотоод Ази болон Умард хятадад бүрэлдэн тогтжээ. Газар тариалан эрхлэхэд нэн тохиромжтой Шар мөрний доод урсгал, Вэй голын хөндий нутгийг “Төв тэгш тал” (中原Zhongyuan) хэмээн нэрлэх бөгөөд энэ нутаг нь хятадын соёлын голомт нутаг юм. Энэ бүс нутгаас хойшоо Хэбэй, Хэси, Шаньси, Шэньси, Ганьсу болон түүнээс хойшхи нутагт эрт үеэс хятадын соёлоос ялгаатай соёл бүхий угсаатнууд оршин байв. Энэхүү өвөрмөц соёл бүрэлдэхэд байгаль газар зүй, цаг уурын өвөрмөц байдал нөлөөлсөн нь тодорхой боловч энэ бүс нутагт оршин суугчдын эрхлэх аж ахуй, соёлын өвөрмөц шинж, гар урлал, урлаг, технологийн хөгжил, нийгэм-эдийн засгийн онцлог дүр төрх нь хүрлийн үеэс улам бүр ялгарах болсон байна. Ийнхүү хятадын соёлоос эрс ялгагдах шинжтэй тул өрнөдийн судлаачид “Умард бүс нутаг” буюу “Northern zone” гэдэг нэр томъёог хэрэглэдэг. Дотоод Ази болон Умард хятадын энэ бүс нутагт тариалангийн соёлоос илүүтэй мал аж ахуйн соёл

ямагт давамгайлж байсан бөгөөд улмаар нүүдлийн мал аж ахуй үүсч, давамгайлах соёл нь болсон билээ. Эдгээр ард түмэн баруун талаараа Индо-европуудтай хиллэн, айлсан суух болсон нь тэдний аж ахуй, соёлын хөгжилд чухал нөлөө үзүүлсэн ажээ. Түүнчлэн тэд эрт үеэс суурин хятадын улсуудтай харилцаж байсан нь тодорхой боловч хятад сурвалжид Шан улсын сүүл үе буюу НТӨ II мянганы сүүл үеэс анх тэмдэглэсэн байна.

Гүйфан (鬼方 guifang) ба Шан улс

Шанулс(НТӨ XVI-1045)-ын сүүл үеэс хятад сурвалжид умардын угсаатнуудыг анх фан (方fang) хэмээх ерөнхий нэрээр тэмдэглэсэн бөгөөд тэднийг дотор нь гүнфан (吉方gongfang), гүйфан (鬼方guifang), түфан (土方tufang), жэнфан (人方renfang) хэмээн ялган нэрлэдэг байжээ. Эдгээр нэрсээс Шан болон Баруун Жоугийн эхэн үед умардын хүмүүсийг нэрлэх түгээмэл нэр нь Гүйфан (鬼方 guifang) байв. “Хулсан номын тэмдэглэл” (竹書紀年zhushu jinian), хүрэл савны бичээсүүдэд гүйфан нэр гардаг.

“Хулсан номын тэмдэглэл” (竹書紀年zhushu jinian)-д өгүүлснээр У-и (武乙 wuyi) вангийн үед:

“三十五年，周公季歷，伐西落鬼戎”. “35 дугаар онд Жоугийн Жили (季歷 jili) гүн баруун аймаг Гүйжун (鬼戎 guirong) руу довтолсон”¹ хэмээжээ.

Хулсан номын тэмдэглэлийн он цагаар бол У-и вангийн 35 дугаар он нь 1123 он бөгөөд энд Гүй болон Жун нэрийг нийлүүлэн Гүйжун хэмээн бичсэн байна.

И-зин (易經yijing) номонд: 高宗伐鬼方，三年克之，小人勿用 хэмээн Ү-дин ван умардын Гүйфанчуудтай гурван жил байлдан, тэднийг буулгаж авсан тухай өгүүлжээ². Эдгээр нь Гүйфаны талаарх хятад сурвалжийн анхны мэдээнүүд юм. Шангийн сүүл үе болон Баруун Жоу (НТӨ 1045-770)-ийн үед гүйфан, сяньюнь, жунчуудтай хийсэн байлдааны ялалтыг алдаршуулж цэргийн жанжидаа шагнаж байсан хүрэл савны бичээсүүд нь тухайн үеийн түүхийг судлах чухал эх сурвалж болж байна. Эдгээр хүрэл савны бичээсүүд тухайн үед бичигдсэн тул анхдагч эх сурвалж болох төдийгүй нүүдэлчидтэй хийсэн байлдааны үйл явцыг дэлгэрэнгүй тэмдэглэсэн ихээхэн баялаг мэдээлэл агуулж байгаагаараа чухал ач холбогдолтой юм. Хамгийн эртний бичээс нь Сяо Үй дин (小孟鼎 xiao yu ding) бичээс юм.

Сяо Үй дин (小孟鼎 xiao yu ding) бичээсэнд Гүйфантай хийсэн байлдааны

¹ 竹書紀年zhushu jinian. (James Legge. The Chinese classics. Vol. 3: The Shoo King, The Annals of the Bamboo books.p. 138)

² Chang K.Ch. *Shang Civilization*. Yale University Press, 1980. p. 12

талаар дэлгэрэнгүй өгүүлдэг. Кан ван (康 kang, НТӨ 1005-978 он)-ийн 25 дугаар он (979 он)-д Үй (盂 yu)-ийн удирдсан Жоугийн цэрэг Гүйфаныг довтолж ялалт байгуулсан бөгөөд энэхүү ялалтанд зориулан Сяо Үй диний бичээс бүхий хүрэл тогоог цутгасан ажээ. Бичээсэн дэх байлдаанаас ирээд ванд Үй 孟-ийн илтгэсэн хэсгийг авч үзвэл, илтгэсэн нь:

王令孟以[□□]伐鬼方, [□□□]馘[□], 執酋三人, 獲馘四千八百又二馘, 俘人萬三千 八十 一人, 俘馬[□□]匹, 俘車卅輛, 俘牛三百五十五牛, 羊卅八羊。孟又告曰: [□□□□], 乎蔑我徵, 執酋一人, 獲馘二百卅七馘, 俘人[□□]人, 俘馬百四匹, 俘車 百[□]輛。

“Вангийн тушаалаар би Гүйфан руу [хх] довтолж, [хх] алж [х]. Гурван удирдагч олзолж, 4802 хүний тоног авч, олзолсон хүн 13081, олзолсон [хх] морь, олзолсон тэрэг 30, олзолсон үхэр 355, хонь 38”. Үй дахин илтгэсэн нь: “[хххх] байлдааны талаар надад мэдэгдсэн нь: нэг удирдагч баривчилж, 237 хүний тоног авч, олзолсон [хх] хүн, олзолсон 104 морь, олзолсон 1[хх] тэрэг”³.

Хэдийгээр бичээсийн зарим нэг ханзыг унших боломжгүй балархай байгаа ч бичээсийн утга бүрэн ойлгомжтой юм. Бичээсээс үзвэл, байлдааныг ерөнхийд нь Үй 孟 удирдсан боловч, наанадаж хоёр замын цэргээр довтолсон байна. Тиймээс Үй эхлээд зөвхөн өөрийн олзлон авчирсан олзыг илтгэж байгаа бөгөөд дараа нь нөгөө замын цэргийн олзолсон зүйлийг илтгэж байна. Эдгээрээс Үй-ийн олзолсон морины тоо болон нөгөө замын цэргийн олзолсон хүний тоо баларч, унших боломжгүй болжээ. Бичээсэнд тэмдэглэснээр, энэ удаагийн дайнд Жоугийн хоёр замын цэрэг Гүйфаныг ялж, олзолж авчирсан зүйлүүдийн тоог нэмж гаргавал:

Удирдагч: $3+1=4$

Хүний тоног: $4802+237=5039$

Олзолсон хүн: $13081 + \square\square = 13081 + \text{хэдэн мянга}$

Морь: $\square\square + 104 = 104 + \text{хэдэн арав}$

Тэрэг: $30 + 1\square\square = 130 + \text{хэдэн арав}$

Үхэр: $355 + ?$

Хонь: $38 + ?$

Бичээсэнд дурдагдан буй аль нэг замын цэргийн Гүйфанчуудаас олзолсон морь ба тэрэгний зарим тоо нарийн мэдэгдэхгүй байгаа боловч, $104 + \text{хэдэн арван морь}$, $130 + \text{хэдэн арван байлдааны тэрэг олзолсон}$ нь тодорхой байна. Гүйфанчуудаас зуу нэлээд гаруй тэргийг нэгэн удаагийн байлдаанаас олзолсноос үзэхэд тэд байлдаанд тэргийг өргөн ажилладаг байжээ. Баруун Жоу болон

³ 商周金文编。陕西出版集团, 三秦出版社。2009. 382-386 頁

Гүйфаны хооронд болсон байлдаан нь тэрэгт цэргийн хүч давамгайлсан тулаан байсан гэж үзэж болно. Харин 104 + хэдэн арван морь олзолсон нь байлдааны тэрэгний морьд байсан уу, эсвэл морин цэрэгт хэрэглэж байсан морьд уу гэдэгт нь тодорхойгүй. Түүнчлэн Үй өөрийн олзолсон 355 үхэр, 38 хонийг илтгэсэн боловч нөгөө замын цэргийн олзолсон үхэр, хонины тухай өгүүлээгүй нь цөөн тоотой олзолсныг онцолж илтгээгүй байж болох юм. Ямарч гэсэн адуу, үхэр, хонь олзолсноос үзэхэд Гүйфанчууд мал аж ахуй эрхэлж байсан нь тодорхой байна. Суурин мал ажуйтай байсан уу, эсвэл нүүдлийн мал аж ахуй байсан уу гэдгийг бичээсээс мэдэх боломжгүй юм.

Бичээсийн мэдээ Жоучуудад “тоног авах” ёс байсан, дайсны тоногийг шатааж ёслол үйлддэг байсныг нотолж байна. Бичээсэнд гарч байгаа “4800 хүний тоног”, “237 хүний тоног” гэдэг нь тоног авсан дайсны тоог илтгэж байгаа хэрэг бөгөөд нийт 5137 хүний тоног авчирч ирсэн ажээ. Бичээсэнд вангийн зарлигаар эдгээр дайсны тоногийг шатааж, Жоугийн сүмд ёслол үйлдэж байгааг тэмдэглэжээ.

Энэ удаагийн дайнд Гүйфанчууд ялагдан, ихээхэн хохирол амсан бууран доройтсон бололтой. Шан династийн үед умардын угсаатнуудыг нэрлэж байсан Гүйфан нэрийг Баруун Жоучууд эхэн үедээ уламжлалыг даган авч хэрэглэж байсныг Сяо Үй диний бичээс харуулж байна. Гэвч цаашид Гүйфан нэрээр умардын угсаатнуудыг нэрлэхээ больж, Баруун Жоучууд умардын угсаатнуудыг Сяньюнь, Цуаньжун гэж нэрлэх болсныг эртний сурвалжийн мэдээ илтгэж байна.

Сяньюнь (xianyun 獬豸), Жун (rong 戎) ба Баруун Жоу

Түүхэн тэмдэглэлд умардын болон баруун хойд зүгийн угсаатнуудыг нэрлэсэн уулын жун (上戎shanrong), сяньюнь (獬豸xianyun), хүнью (葷粥hunyu), сүнью (熏育xunyu), нохой жун (犬戎quanrong), баруун жун (西戎xirong), жун (戎rong), ди (狄di) гэх мэтийн олон нэр гардаг. Сяньюнь (獬豸xianyun), хүнью (葷粥hunyu), сүнью (熏育xunyu), [сүнью 獯鬻xunyu] нэрийг Хүннү нэрийн эртний хувилбар гэж зарим судлаачид үздэг⁴ боловч нэрийн ойролцоо дуудлагаас өөр тэднийг хооронд холбох түүхэн баримт байхгүй тул ихэнх судлаачид хүлээн зөвшөөрдөггүй билээ.

Эртний хятад сурвалжид умардын угсаатнуудыг оноосон болон ерөнхий нэрээр тэмдэглэх уламжлал байсан, хожмын сударчид ерөнхий нэрийг түлхүү хэрэглэсэн гэдгийг үндэс болговол, эдгээр нэрийг Цин улсаас өмнөх сурвалжид тэмдэглэгдсэн нэр, Хань улсын үеийн хятадын төрийн албан ёсны түүх бичлэгт

⁴ 王國維。鬼方昆夷獬豸考。觀堂集林。石家庄， [1928] 2001. 369-383頁。Сүхбаатар Г. Монголчуудын эртний өвөг. Улаанбаатар: 1980.

тэмдэглэгдсэн нэр гэж ялгаж болох юм. Сяньюнь (獫狁 xianyun), сүнью (熏育 xunyu) гэж зөвхөн Хань улсын үеийн сурвалжид эхлэн гарч байгаа бол сяньюнь (獫狁 xianyun), сүнью (熏育 xunyu) нэр Цин улсаас өмнөх сурвалжуудад тэмдэглэгдсэн, эдгээр нэрийн эртний хэлбэр юм. Сяньюнь (獫狁 xianyun) хэмээн баруун Жоугийн үе (НТӨ 1045-771)-ийн хүрэл савны бичээсүүдэд гарч байгаа нь энэ нэр хамгийн эртний бөгөөд баруун Жоу нарын бодитой нэрлэж байсан нэр хэмээн үзэх үндэслэл болж байна.

Судлаачид Сяньюнь 獫狁 нарыг Жун нартай ойролцоо үед түүхэнд гарч ирж, хятад сурвалжид тэмдэглэгдсэн хэмээн үздэг. Гэтэл Сяньюнь 獫狁 нь Жоугийн баруун хойно орших угсаатны оноосон нэр, харин Жун гэдэг нь баруун, баруун хойд талын дайсагнасан угсаатныг нэрлэх ерөнхий нэр байсан болохоор зарим тохиолдолд ээлжлэн тэмдэглэх явдал байжээ. Тухайлбал, Шүлгэлсэн номын “Чүчэ 出車” хэмээх Сяньюньтай хийсэн нэгэн удаагийн байлдааны тухай шүлэгт эхлээд “Сяньюнь 獫狁”-тай дайтаж байгаа талаар өгүүлсэнээ, дараа нь “Баруун Жун 西戎”-тай байлдаж байгаа хэмээн хольж бичсэн⁵ нь энэ хоёр нэрээр нэг угсаатныг нэрлэдэг байсныг харуулж байна. Баруун Жоугийн үеийн хүрэл савны бичээсүүдэд мөн адил Сяньюнь болон Цуаньжун, Сыжун нэрийг сольж бичсэн тохиолдол хэд хэд байдаг. Тиймээс Сяньюнь бол Баруун Жоу нараас баруун хойно орших угсаатнаа нэрлэдэг оноосон нэр, харин Цуаньжун (нохой жун), Сыжун (баруун жун) нэр нь ерөнхий нэр байсан гэж үзэж болно. Энэ нь Байлдаант улсын үед “Ху” гэж умардын угсаатнуудыг ерөнхийд нь нэрлээд, Хүннү нь түүний доторх нэг улсыг нэрлэсэн оноосон нэр байсан, ху нарыг дунху, линху гэх мэтээр дотор нь ялган нэрэлдэг байсантай адил юм. Эртний хятадын түүх бичлэгээс хөрш угсаатнуудаа ингэж нэрлэх уламжлал байсан жишээг төвөггүй олж болно.

Эртний хятадын династууд хөрш угсаатнуудаа оршин байгаа зүгээр нь нэрлэдэг ерөнхий нэртэй байсан бөгөөд, тухайлбал, умардын угсаатнуудыг Баруун Жоугийн үед Жун, Зүүн Жоугийн үед Ди, Байлдаант улсын үеэс Ху хэмээх ерөнхий нэрээр нэрлэж байв. Гэвч умардын угсаатнууд нэгдмэл биш, дотроо олон янз болохоор тэднийг уулын, нохой, баруун, умард, улаан, цагаан гэх мэтээр ялгаж нэрлэхээс гадна, хамгийн хүчирхэг, дайсагнадаг, харилцдаг угсаатнаа оноосон нэрээр бусдаас нь ялган нэрлэж, эртний бичээс, сурвалжуудад тэмдэглэн үлдээжээ. Тийм оноосон нэрээр тэмдэглэгдсэн угсаатны нэг нь Сяньюнь болно. Сыма Цяний “Түүхэн тэмдэглэл”-ийн “Жоугийн бүлэг”-т бичсэнээр Баруун Жоу

⁵ 詩經shijing, (James Legge. The Chinese classics. Vol. 4: The She King. pp. 261-265).

улс Вэй голоор төвлөрөн байгуулагдахад Сүнью (熏育 xunyu) нарын довтолгоо гол нөлөө үзүүлсэн бол, мөн бууран доройтож, Зүүн Жоу улс байгуулагдсан нь Цуаньжун нарын довтолгооноос болсон ажээ. Түүхэн тэмдэглэлд гарч байгаа энэхүү Сүнью (熏育 xunyu), Цуаньжун хэмээх нь Сяньюнь мөн бололтой бөгөөд Баруун Жоугийн үеийн хүрэл савны бичээсүүд, “Шүлгэлсэн ном” (詩經 shijing)-ын шүлгүүдэд Сяньюнь нартай байлдсан цуврал олон байлдааны тухай өгүүлж байна. Шүлэглэсэн ном (詩經 shijing)-д Сяньюнь ба Жоугийн хоорон дахь байлдааны талаар Цай вэй (采薇 cai wei), Чүчэ (出車 chu che), Лю юэ (六月 liuyue, 6 сар), Цайчи (采芑 caiqi)⁶ гэсэн дөрвөн шүлгэнд тухайлан өгүүлдэг. Сүүлийн үеийн археологийн малтлагаар Жоугийн үеийн хүрэл савны бичээс олон олдсоноос Дүо Ю дин (多友鼎 duo you ding), Сы Зиа пан (兮甲盤 xijia pan), Гози Зибай пан (虢季子白盤 Guoji zibai pan), Бү Чи гүй (不其簋 buqigui) бичээсүүдийг Сяньюнь болон Баруун Жоугийн хооронд болсон байлдаанд зориулан үйлджээ. Түүнчлэн “Хулсан номын тэмдэглэл”, “Улсын өгүүлэл” (國語 guo yu) зэрэг эртний сурвалжууд, Түүхэн тэмдэглэл зэрэг Хань улсын үеийн сурвалжид Сяньюнь нарын талаар тэмдэглэл буй.

Сяньюнний талаар хамгийн анхны хятад сурвалжийн мэдээ Баруун Жоугийн Мү вангийн үе (956-918)-д холбогдох бөгөөд Цуаньжунгийн эсрэг довтолсон талаарх Го үй-ийн мэдээг “Түүхэн тэмдэглэл”-ийн Жоугийн цадигт эшлэн “дөрвөн цагаан чоно (四白狼 sibailang), дөрвөн цагаан буга (四白鹿 sibailu) олзолсон” хэмээн тэмдэглэсэн байдаг⁷. Мү вангийн үед Жунчууд болон Жоугийн хооронд болсон цуврал олон байлдааны талаар “Хулсан номын тэмдэглэл” (竹書紀年 zhushu jinian)-д Мү (穆 mu) вангийн үед,

“十二年，毛公班，共公利，逢公固帥師從王伐犬戎。冬十月，王北巡狩，遂征犬戎。十三年春，祭公帥師從王西征，次于陽紆。秋七月，西戎來賓。徐戎侵洛。十四年，王帥楚子伐徐戎，克之”。

“12 дугаар онд Маогийн гүн Бань (毛公班 Maogong Ban), Гүнгийн гүн Ли (共公利 gonggong Li), Фэнгийн гүн Гү (逢公固 fenggong Gu) нар вантай хамтран Цуаньжун (犬戎 quanrong) нарыг довтлов. Өвөл 10 сард ван умард зүг аялж, Цуаньжун нарыг довтлон шийтгэсэн. 13 дугаар онд Зи гүн вантай хамт цэргээ удирдан, баруун зүг аян дайнд мордож, Ян Ю хүрэв. Зун 7 дугаар сард, Баруун жун дагаар орохоор ирэв. Сүжун 徐戎-чууд Лүо руу довтлов. 14 онд ван Чү-ийн

⁶ 詩經 shijing, (James Legge. The Chinese classics. Vol. 4: The She King., pp. 258-261, 261-265, 281-284, 287)

⁷ 國語 (guo yu). I, 1-8頁; 史記. 第4 卷, 第135-136頁

язгууртны хамт Сүжунг довтлон, тэднийг эрхшээлдээ оруулав”⁸ хэмээжээ.

Мү вангийн Жоу болон Жунчуудын хооронд олон удаагийн байлдаан болжээ. 12 дугаар онд Мү ван хоёр удаа Цуаньжунгийн эсрэг довтолсон. Харин 13 дугаар онд баруун тийш аян дайн хийсэн гэсэн нь Жунгийн эсрэг дайн байсан бололтой. Дараа жилийн 7 дугаар сард нь Баруун жун (西戎xirong) дагаар орохоор ирж байгаагаас үзэхэд тэгж дүгнэж болох юм. Гэвч Сүжунчууд (徐戎xurong) Лүо хот руу довтолжээ. 14 дүгээр онд Мү ван Сүжунтай дайтан тэднийг эрхшээлдээ оруулсан тухай “Хулсан номын тэмдэглэл” –ын Мү вангийн хэсэгт тэмдэглэжээ. “Го үй”-д дурдсанаар Мү вангийн энэ довтолгооны дараа Жунчууд Жоугийн нутаг дэвсгэрт дахин үзэгдэхээ больсон⁹ хэмээснээс үзэхэд Жоучууд Жунчуудыг баруун хойд зүг шахаж, газар нутгаа умар зүг тэлсэн нь тодорхой байна.

Мү вангийн дараа үеэс Жоугийн нэгдмэл байдал алдагдаж, улс төрийн задралын удаан үргэлжилсэн үйл явц эхэлжээ.

“Хулсан номын тэмдэглэл”-д И ван (懿王Yih 899/97-873)-ийн үед,

“七年，西戎侵鎬。二十一年，虢公帥師北伐犬戎，敗逋”.

И ван (懿王Yihwang)-ын 7 дугаар он (НТӨ 891 он)-д Баруун жунчууд Хао (鎬hao) руу довтлов. 21 дүгээр онд Го гүн (虢公guogong) цэргээ умар зүг удирдан Цуаньжун нарыг довтолсонч ялагдсан¹⁰.

Дээрх мэдээнээс үзэхэд НТӨ 891 онд Баруун жунчууд Жоугийн нутагт гүнзгий цөмрөн орж, нийслэл Хао 鎬 хот руу хандан довтолсон ажээ. Хулсан номонд байлдааны үйл явцын талаар мэдээлээгүй. Харин 21 дүгээр онд Го гүн (虢公guogong) цэргээ удирдан Цуаньжун нарыг довтолсон боловч ялагдсан байна. И ван (夷王Yiwan 865-858)-ийн үед:

“七年，虢公帥師伐太原之戎，至于俞泉，獲馬千匹”.

7 дугаар онд, Го гүн цэргээ удирдан Жун руу довтолж, Тайюань (太原taiyuan)-аас алс Юйчюань (俞泉yuquan) хүрч 1000 морь олзлов¹¹.

Ийнхүү И ван (夷王Yiwan)-ийн үед Жоугийн цэрэг Го гүнгийн удирдлагаар Жунгийн Тайюань руу довтлон, Ю-чюань хүрч, мянган морь олзолсон ажээ. Ю-чюань нь хилээс нэг их хол биш орших Жунгийн газрын нэр бололтой. Жоугийн энэ удаагийн довтолгоо нь Жунгийн нутгийн гүнд хийсэн томоохон довтолгоон

⁸ 竹書紀年zhushu jinian, (James Legge. The Chinese classics. Vol. 3: The Shoo King, The annals of the Bamboo books. p. 150).

⁹ 國語(guo yu). I, 8頁;

¹⁰ 竹書紀年zhushu jinian, (James Legge. The Chinese classics. Vol. 3: The Shoo King, The annals of the Bamboo books. The annals of the Bamboo books. p. 152)

¹¹ 竹書紀年zhushu jinian, (James Legge. The Chinese classics. Vol. 3: The Shoo King, The annals of the Bamboo books. p. 153)

байсан нь тодорхой байна. Мянган морь олзолсон гэдэг нь ихээхэн сонирхолтой мэдээ бөгөөд нэг удаагийн довтолгооноор ийм олон морь олзолж байгаагаас үзэхэд, Жунчууд адуу олонтой байсныг гэрчилж байна.

Ли ван (857/53-842/28)-ийн үед Сяньюнь нар Жоугийн нутаг руу томоохон хэмжээний довтолгоо хийв. 1980 онд Шэньси мужийн Сы-ань хотоос баруун зүгт байдаг Чаньганиас олсон, 270 гаруй ханз үсэг бүхий томоохон бичээс болох Дүо Ю дин (多友鼎 duo you ding) бичээсэнд Сяньюнь болон Баруун Жоугийн хоорондын байлдааны тухай өгүүлж байна. Дүо Ю диний тогооны бичээсэнд:

唯十月，用嚴（獵）駘（狁）放興，廣伐京師告追于王。命武公：“遣乃元士，羞追于京師”，武公命多友：率公車羞追于京師。

癸未，戎伐筍，衣孚（俘）。多友西追，甲申之晨，搏于鄴（漆），多友右折首、執訊。凡以公車孚折首二百又[口口]又五人，執訊二十又三人，孚（俘）戎車百乘一十又七乘，衣復筍人孚（俘）。或搏于龔，折首卅（三）又六人，執訊二人，孚（俘）車十乘。從至，追搏于世，多友或右折首、執訊。乃軼追于楊塚。公車折首百又十又五人，執訊三人，唯孚（俘）車不克，以衣（已）焚，唯馬毆盡。復奪京師之孚（俘）。

“10 сард, Сяньюньчууд*¹² Зинши (京師jingshi) рүү томоохон довтолгоо хийж дайн үүсгэв. Энэ тухай ванд мэдээлэв. Вангаас Ү гүн (武公wugong)-д “шилдэг цэргээ илгээн, Зиншигээс [дайсныг] хөөн гарга” гэж тушаасан. Ү вангаас Дүо Ю (多友 duo you)-д “Байлдааны тэрэгт цэргээ удирдан Зиншигээс хөөн гарга” гэж тушаав”. Харагчин хонь өдөр Жунчууд* Сүн (筍 xun) рүү довтолж, хүмүүсийг нь олзолсон. Дүо Ю баруунш мөрдөн, хөх бич өдрийн өглөө нь хүрч ирээд Чи (漆qi) рүү довтлов. Дүо Ю 2[X]5 хүн алж, 23 хүн олзолж, рунчуудын 117 тэргийг булааж авч, олзлогдсон Сүн хүмүүсийг чөлөөлөв. Гүн (龔 gong) рүү довтолж, 36 хүн алж, 2 хүн баривчилж, 10 тэрэг олзлов. Улмаар [Сяньюнийг] мөрдөн хөөн Ши (世 shi) рүү довтлов. Дүо Ю бас алж олзлов. [Дүо Ю] шаламгайгаар мөрдөн хөөж, Янжун (楊冢 yangzhong)-д ирэв. Тэрэгт цэрэг 115 хүнийг алж, гурван хүн олзлов. Энэ удаад [Сяньюньчууд] тэргээ шатаасан тул тэрэг олзолж чадсангүй. [Сяньюний] өөөдсөн (туйлдсан) морь олон байв. [Дүо Ю] Зиншиг буцаан авав”¹³.

¹² Бичээсийн эхэнд Сяньюнь нар довтолсон тухай өгүүлж байснаа дараахан нь Жунчуудын довтолгоо хэмээн энэ хоёр нэрийг хооронд нь хольж хутгаж нэрлэсэн. Тухайн цаг үед нь үйлдсэн энэ бичээс энэ хоёр нэрийг хольж бичсэн нь Баруун Жоучууд хөрш нүүдэлчдээ оноосон болон өрөнхий нэрээр нэрлэж, тэр нэрээ хольж хэрэглэдэг байсныг гэрчилж байна.

¹³ 田醒农, 雒忠如. 多友鼎的发现及其铭文试释. // 人文杂志. 1981 年, 第4 期, 116 页; 中國青銅器全集. 册 5. 文物出版社. 1997. 62, 34 頁; 李仲操 (lizhongcao). 也釋多友鼎銘文. 人文杂志. 1982 年, 第6 期, 95-99 頁. Shaughnessy Edward. The Date of the “Duo You ding” and its Significance. // *Early China*. 90-10. 1983-1984. p. 57.

Бичээсийн төгсгөлд баривлагдсан хүмүүс, олзолсон зүйл болон дайсны тоногийг Ү гүнд илгээсэнд, Ү гүнээс ванд илгээсэн. Вангаас Зиншиг чөлөөлсөний төлөө түүнийг газраар шагнасан болон Ү вангаас Дүо Ю-г хөхүүлэн шагнаж, байлдааны ялалтыг тэмдэглэсэн тухай өгүүлж байна. 270 гаруй ханз бүхий энэ томоохон бичээсэнд Сяньюнь нарын довтолгоо болон түүний эсрэг Баруун Жоу нарын хийсэн нэгэн удаагийн дайны талаар тодорхой өгүүлсэн байна. Нэгэн удаагийн байлдааны талаарх энэхүү тэмдэглэлд Сяньюнь, Жун нэрийг хольж бичиж байгаа нь Жун бол ерөнхий нэр, Сяньюнь нь оноосон нэр бөгөөд хооронд нь хольж хэрэглэх явдал түгээмэл байсныг бас баталж байна. Бичээсэнд дурдсанаар Сяньюнь нар Жоугийн Зинши хэмээх газар руу эхлээд довтолсон бөгөөд энэ газар нь Жоугийн хилийн ойролцоох томоохон газар бололтой. Жоугийн ван Ү гүнд цэргээ авч Зиншиг хамгаалахыг зарлиг болгоход, Ү гүн өөрийн тэрэгт цэргийг Дүо Ю-аар удирдуулан Сяньюний эсрэг илгээсэн байна. Энэ үед Сяньюньчүүд Сүн хэмээх газар руу довтлон эзэлж, хүмүүсийг нь олзолсон. Дараа өдөр нь Дүо Ю цэргээ удирдан ирж, Сяньюний эсрэг довтолсон бөгөөд энэ шийдвэрлэх байлдаан Чи хэмээх газар болжээ. Энэ байлдаанд Жоучууд ялж, Сяньюний хоёр зуу гаруй хүнийг алж, 117 байлдааны тэрэг, 23 хүн олзолсон. Жоугийн цэрэг Сяньюний цэргийг мөрдөн хөөж, Гүн болон Ши-д байлдаж бас ялжээ. Энэ байлдаанд алагдсан болон олзолсон хүний тоо цөөн байгаагаас үзэхэд том хэмжээний байлдаан биш жижиг тулгаралт бололтой бөгөөд дахин 10 тэрэг олзолсон байна. Дүо Ю мөшгөн хөөж, Янжун хэмээх газар Сяньюний цэргийг дахин цохиж, 115 хүн алж, 3 хүн олзолсон бөгөөд Сяньюний цэрэг ухрахдаа байлдааны тэргээ шатаасан тул энэ удаа тэрэг олзолж чадаагүй ажээ. Сяньюний цэрэг шархадсан морьдоо орхин зугтсан. Жоугийн цэрэг Сяньюний цэргийг мөрдөн хөөсөөр Зиншиг чөлөөлсөн байна. Ийнхүү энэ удаагийн Сяньюнь нарын довтолгоо амжилтгүй болж, Дүо Ю-ийн удирдсан Жоугийн тэрэгт цэрэг ялжээ. Энэ байлдаан нь хоёр талын цэрэгт цэргийн тулаан байсан нь бичээсэнд тодорхой тэмдэглэгдсэн бөгөөд Жоугийн цэрэг эхний тулаанд Сяньюний 117 байлдааны тэргийг, дараа нь 10 тэргийг тус тус олзолсон. Сүүлийн тулаанд Сяньюнь нар ухрахдаа байлдааны тэргээ олзлуулахгүйн тулд шатаасан байна. Шархатсан морь маш олон үлдсэн байсныг дурьдсанаас үзвэл, байлдааны тэргэнд хөлөлдөг морьд нь шархтаж, алагдсан учраас Сяньюнь нар тэргээ шатаагаад ухрахаас аргагүй болсон бололтой. Сяньюнь болон Баруун Жоугийн хооронд болсон нэгэн удаагийн дайны үйл явцыг тодорхой дүрсэлсэнээрээ Дүо Ю дин бичээс онцлогтой бөгөөд энэхүү хэдэн удаагийн

байлдаанд Доу Ю ялж, түүний алж, олзолсон хүн болон тэрэгний тоог нэгтгэвэл:

		Ци (漆 qì)	Гүн (龔 gōng)	Ши (世 shì)	Янжун (楊冢 yangzhong)	Бүгд	Тайлбар
1	Алсан хүний тоо	2[x]5	36	?	115	356+	
2	Олзолсон тэрэгний тоо	117	10	?	Сяньюньчүүд тэргээ шатаасан	127+	Сяньюньчүүд хэдэн тэргээ шатаан зугтсан нь тодорхойгүй
3	Олзолсон хүний тоо	23	2	?	3	28	Янжунд сяньюний шархадсан морь олон

Янжунд болсон тулалдаанд, Сяньюньчүүд хэдэн тэргээ шатаан зугтсан нь тодорхойгүй, шархатсан морьд маш олон байжээ.

Дүо Ю дин бичээс нь Сяньюнь буюу Жун нар тэрэгт цэрэгтэй байсныг нотлон харуулж байгаагаараа онцгой чухал ач холбогдолтой юм. Бичээсээс Сяньюнь нар морин цэрэгтэй байсан эсэх нь мэдэгдэхгүй боловч, Жоу нарын нэгэн адил морь хөлөлдөг тэрэгт цэрэгтэй байсан, тэдний хооронд тэрэгт цэргийн тулаан өрнөж байсныг нотолж байна.

Хятадад тэрэг хэрхэн нэвтэрсэн тухай судалгаа нэлээд байдаг ч Дотоод Азийн нүүдэлчид хэдий үеэс тэрэг хэрэглэх болсон болон байлдааны тэрэг хэрэглэж байсан эсэх нь тодорхойгүй байдаг. Ер нь эртний хятадууд хэдий үеэс нүүдэлчидтэй, морьт дайчидтай харилцаж эхэлсэн асуудал ихээхэн маргаантай асуудал юм. Хятадын уламжлалт түүх сурвалжийн мэдээг үндэслэн судлаачид НТӨ IV зуун буюу Байлдаант улсын үеэс умардын нүүдэлчид, морьтон дайчидтай харилцаж эхэлсэн гэж үздэг билээ.

“Хулсан номын тэмдэглэл”-д өгүүлснээр, Ли 厲 вангийн 14 дүгээр он (НТӨ 838 он)-д Сяньюнь нар довтолж, Баруун Жоугийн нутагт гүнзгий цөмрөн орсон ч тэднийг Жаогийн цэрэг шахан гаргаж чаджээ¹⁴.

Суань ван (宣王 xuan wang) Баруун Жоугийн задралыг зогсоон, улс төрийн нэгдмэл байдлыг сэргээж чадсан билээ. Суань вангийн үе (827-782)-д Сяньюнь буюу Цуаньжунгийн эсрэг олон довтолгоог хийсэн талаар “Хулсан номын тэмдэглэл”-д тэмдэглэсэн байна.

“Хулсан номын тэмдэглэл”-ийн Суань вангийн хэсэгт тэмдэглэснээс үзэхэд, 3 дугаар он (НТӨ 825 он)-д Суань вангийн тушаалаар Жун (仲 zhong) цэргээ удирдан Баруун жун нарыг анх довтолсон ажээ. 5 дугаар он (НТӨ 823 он)-ы 6

¹⁴ 竹書紀年 zhushu jinian, (James Legge. The Chinese classics. Vol. 3: The Shoo King, The annals of the Bamboo books. p. 154)

сард Инъзифү (尹吉甫 yinjiifu)-ийн удирдсан Жоугийн цэрэг Сяньюнийг довтолж, Тайюанийг өнгөрч, Сяньюний нутагт гүнзгий цөмрөн орсон нь тодорхой байна. 6 дугаар он (822 он)-д Жоугийн ван цэргээ удирдан Сүжун (徐戎 xurong) руу довтолсон ажээ. Баруун жунчууд Цинь Жун 秦仲 (Цинь улсын удирдагч Zhong)-ыг алсан гэжээ¹⁵. Суань вангийн үеийн Сяньюнь буюу Баруун жунтай хийсэн Жоугийн удаа дараагийн эдгээр байлдааны тухай “Түүхэн тэмдэглэл”-ийн “Цин улсын үндсэн тэмдэглэл”-д

Суанийг Жоугийн ван болоход Цин улсын удирдагч Жун (仲 zhong) Баруун жунгийн эсрэг довтолохыг санал болгосон, гэвч Жунчууд түүнийг алсан. Цингийн Жун таван хүүтэй, ахмад хүү Жуан гүн түүнийг залгамжилж, Суань вангийн 7000 цэрэгтэй хүч хавсран Жунчуудыг довтолж, ялалт байгуулсан. Жуан гүн гурван хүүтэй, түүний ахмад хүү Шифү: “Жунчууд миний өвөө Цин Жунийг алсан. Жунгийн удирдагчийг алах хүртлээ би залгамжлагч болохгүй” хэмээв. Тэрээр цэргээ удирдан Жун руу довтолж, ялалт байгуулсан¹⁶ хэмээн тэмдэглэсэн байна.

Цин улс нь Вэй голын дээд урсгал, Тяньшүй голын хөвөөнд оршин байсан бөгөөд Сяньюньтай Вэй голын дээд урсгал орчмоор хиллэж байсан бололтой.

Сяньюнь ба Баруун Жоугийн хоорондын дайны тухай өгүүлсэн “Шүлгэлсэн ном”-ын шүлгүүд болон Баруун Жоугийн үеийн хүрэл савны бичээсүүд нь сурвалжийн мэдээг өргөтгөж, шинэ мэдээлэл өгч байгаагаараа онцгой чухал ач холбогдолтой юм. “Хулсан номын тэмдэглэл”, “Го үй”-ийн мэдээг “Шүлгэлсэн ном” (詩經shijing)-ын Цай вэй (采薇caiwei), Чүчэ (出車 chuche), Лю юэ (六月 liuyue), Цайци (采芑cai qi) шүлгүүд болон Сы Зиа пан (兮甲盤 xijia pan), Гози Зибай (虢季子白盤 Guoji zibai pan), Бү Ци гүй (不其篋 buqigui) бичээсүүдийг харьцуулан судалснаар эдгээр дайны талаар шинэ гаргалгаа дүгнэлт хийх боломжийг олгож байна.

Сы Зиа пан (兮甲盤 xijia pan)-ы бичээсэнд “Тавдугаар оны гурван сард ...ван анх удаа Сяньюнь нарыг Тү Үй-д довтлов. Ванг Сы Зиа дагалдан алж, олзолж байв”¹⁷ хэмээжээ. Энэ байлдаан Суань вангийн 5 дугаар он (НТӨ 823 он)-ы 3

¹⁵ 竹書紀年zhushu jinian, (James Legge. The Chinese classics. Vol. 3: The Shoo King, The annals of the Bamboo books. p. 155)

¹⁶ 史記 shi ji. 第4卷. 第178頁

¹⁷ Edward L. Shaughnessy. *Sources of Western Zhou History: Inscribed bronze Vessels*. University of California Press, 1991. p. 141; Li Feng. *Landscape and Power in Early China: The Crisis and Fall of the Western Zhou, 1045-777*. Cambridge University Press. 2006. p. 151. 马承源 (Ma Cheng-yuan). 記上海博物館新收集的青銅器, 文物, 1967 年. 第7 期, 10-14 页;

дугаар сард болжээ. Сы Зиа паны бичээсэнд гарч байгаа энэхүү байлдааны тухай Шүлгэлсэн номны “Лю юэ” (Зургаан сар) шүлгэнд мөн өгүүлж байгаа бөгөөд олон сар үргэлжилсэн дайн зургаан сард Жоугийн цэргийн ялалтаар төгсчээ хэмээн судлаачид үздэг¹⁸. Сурвалжуудад хэдэн сард байлдаан эхэлснийг тодорхойгүй дурьдаагүй боловч “Лю юэ” (6 сар) шүлгэнд Сяньюньчүүд Жоугийн нутагт гүнзгий цөмрөн, Зяохуо (蕉獲 jiāohuò)-г эзлэн, Жоугийн нийслэл Хао (鎬 hào) болон Фан (方 fāng) рүү Зинян (涇陽 jīngyáng)-ы замаар давшиж байсан талаар өгүүлж байна. Ийм үед Суан ван өөрийн цэргийг Зифү (吉甫 Jífū)-д захируулан довтолж, Сяньюний цэргийг цохин, Тайюаниас цааш хөөн гаргасан бөгөөд энэ ялалт зургаан сард болсон¹⁹ тухай өгүүлдэг. Сы Зиа пан-ы бичээсэнд “5 дугаар оны 3 сард ван анх удаа Сяньюнь рүү довтолсон” хэмээгээд вангийн анхны довтолгоо амжилттай болсныг тэмдэглэснээс үзэхэд, дайн гурван сар гэхэд аль хэдийн эхэлсэн байсан ажээ. Гэвч Сяньюний цэрэг ялалт байгуулж давшсаар Зяохуог эзлэн, Зин голын хөвөө хүрч, Жоугийн Хоа болон Фан нийслэлд тулж ирж аюул учруулсан байна. Хүрэл савны бичээсийг ялалтыг тэмдэглэн, ялалтанд зориулж цутгаж байсан болохоор дайны энэ ялагдсан үеийн талаар өгүүлээгүй бөгөөд “Хулсан номын тэмдэглэл”-д ч гэсэн дайны үйл явцыг нарийн тэмдэглээгүй ажээ. Харин “Лю юэ” шүлгэнд олон газрын нэр дурдагдаж байгаа нь дайны өрнөлийг сэргээн мэдэх боломж олгож байна.

Гожи Зибай пан (虢季子白盤 Guó jì zī bāi pán) бичээсэнд 12 дугаар он (НТӨ 816 он)-ы 1 дүгээр сард энэ бичээсийг цутгасныг дурдаад:

“ЗибайЛүо голын хойно Сяньюнийг довтолж, 500 хүнийг алж, 50 хүн олзлов”²⁰ хэмээсэн бол Бү Ци гүй (不其篋 buqígūi) бичээсэнд:

唯九月初吉戊申，白（伯）氏曰：不其，馭方、玁狁廣伐西俞，王令我羞追于西，余來歸獻擒，余命汝禦追于略，汝以我車宕玁狁于高（陶），汝多折首，執訊。戎大同，從追汝，汝徼戎大敦搏，汝休弗以我車陷于艱，汝多擒，折首執訊。²¹

“9 дүгээр сард wushen өдөр (no. 45) Боши өгүүлрүүн: “Бүчи, хил хамгаалагч!, Сяньюньчүүд Сы-юй (西俞 xīyū)-г хүчтэй довтолсонд, вангийн зарлигаар бид

¹⁸ Li Feng. *Landscape and Power in Early China: The Crisis and Fall of the Western Zhou, 1045-777*. Cambridge University Press. 2006. p. 153.

¹⁹ Waley, *The Book of Songs*, p. 150. 詩經 shījīng, (James Legge. *The Chinese classics*. Vol. 4: *The Shu King*. p. 283)

²⁰ 中國青銅器全集. 冊 6. 文物出版社. 1997. 69, 139 頁; 郭沫若 (guómòruò). 兩周金文辭大係圖錄考釋. 冊 8. 北京. 1958. 104-106 頁.

²¹ 滕縣后荆沟出土不其篋等青銅器群. // 文物. 1981 年. 第 9 期, 26-27 頁; 中國青銅器全集. 冊 6. 文物出版社. 1997. 66, 77 頁;

тэднийг баруун тийш хөөв. Би олзлогдогсдыг аван буцан ирсэн. Би чамд Ло (答 luó) хүртэл хөөхийг тушаасан. Чи тэрэгт цэргийг удирдан Гао-инь (高陰 gaoyīn)-д Сяньюньчүүд рүү довтолж, олон дайсныг алж олзлов. Гэнэт Жунчууд асар олноор цугларч, чамайг даган мөшгөхөд, Жунчуудтай ширүүн байлдаан хийж, их хохирол учруулав. Энэхүү хүнд үед чи тэрэгт цэргийг сайн удирдан, авч гарч ирж чадлаа. Чиний алсан, олзолж баривчилсан хүн маш олон”” хэмээгээд бичээсийн төгсгөлд Бүчиг хөхүүлэн шагнасан тухай өгүүлж байна.

Дээрх хоёр бичээсэнд тэмдэглэснээс үзвэл, Сяньюнь нар Сы-үй рүү довтолоход, вангийн зарлигаар цэргийн удирдагч Боши Сяньюний довтолгоог няцаан, тэднийг баруун тийш шахсан бөгөөд өөрөө олзлогдогсдыг аван буцсан байна. Тэрээр Бүци-д тэрэгт цэргээ удирдан, тэднийг Ло хүртэл мөшгөн хөөхийг тушаасан ажээ. Бүци цэргээ удирдан Гао-инь хэмээх газар Сяньюний цэргийг довтлон цохиж, олон дайсныг устган, олзолсон байна. Гао-инь нь Сяньюний нутагт байдаг газар бололтой. Гэнэт Сяньюнь нар олноор цугларч, Жоугийн цэргийн эсрэг гэнэтийн цохилт хийжээ. Хүнд байдлаас амжилттай гарч, тэрэгт цэргийг хохирол багатайгаар авч гарч ирсэн хэмээн Бүци-г сайшаан шагнаж байгаагаас үзэхэд, Жоугийн цэрэг Сяньюнь нарын тавьсан урхинд орсон байж болох юм. Бодвол, Сяньюнь нарын цохигдон ухарсан нь байлдааны тактик байсан бөгөөд мөрдөн хөөж байгаа Жоугийн цэрэг урхинд орсон бололтой. Эндээс үзэхэд, Сяньюньчүүд гэнэтийн довтолгоо хийдэг, мөрдөн хөөж байгаа дайсныг отолтон оруулах зэрэг нүүдэлчдийн түгээмэл ашигладаг байлдааны тактикийг хэрэглэдэг, тэрэгт цэрэг бүхий армитай, магадгүй морин цэрэг ашиглаж эхэлж байсан байж болох юм. “Бү Ци гүй” бичээсэнд “9 дүгээр сар” хэмээн сарыг тодорхой тэмдэглэсэн ч хэдэн онд болсоныг тэмдэглээгүй. Судлаачид цутгалтын хэв маяг, чимэглэл нь “Този Зибай пан” бичээстэй адил төстэй байдлыг үндэслэн ойролцоо үед, магадгүй нэг хүн цутгасан хэмээн үздэг. Тиймээс “Този Зибай пан” 12 дугаар он (НТӨ 816 он)-ы 1 дүгээр сард цутгасан гэсэн бичээсийн мэдээг үндэслэн, “Бү Ци гүй”-г Суан вангийн 13 дугаар он (НТӨ 815 он)-ы 10 сард буюу Зибай-н удирдсан байлдаанаас нэг жил гаруйн дараа болсон байлдааны тухай өгүүлж байна хэмээн үздэг²² билээ. Жоугийн цэргийн ялалтыг тэмдэглэн цутгасан хүрэл савны бичээсүүдэд ялалтын талаар өгүүлсэн байдаг бол “Хулсан номын тэмдэглэл”-д Суан вангийн 35 дугаар он (НТӨ 797 он)-д Жоугийн цэрэг Сяньюний эсрэг Тайюань руу довтолсон боловч ялагдсан тухай тэмдэглэсэн байна.

²² Shaughnessy Edward. The Date of the “Duo You ding” and its Significance. // *Early China*. 90-10. 1983-1984. p. 57.

Суан вангийн үеийн Сяньюнь рүү довтолсон сүүлчийн аян дайны талаар 42 дугаар он (НТӨ 786 он)-д цутгасан “42 оны Лай дин” (逖鼎lai ding) бичээсэнд тэмдэглэн үлдээжээ. Энэхүү бичээсэнд:

佳卅又二年五月,...兵獵狁，出捷于井阿，于磨讖，汝丕[□]戎。汝[□]長父，以追搏戎，乃即宕 伐于弓谷，汝執訊獲馘，俘器、車、馬。汝敏于戎工，弗逆朕親命。²³

“42 дүгээр оны 5 дугаар сард ... Сяньюний цэрэг гарч ирж, Зин-А болон Лихан рүү довтолсон. Чи Жун руу [х]-гүй, чи [х] Жанфү Жунчуудыг хөөн цохиж, чи Гүнгү рүү томоохон дайралт хийв. Чи дайсныг алж, баривчилж, морин тэрэг болон эд зүйл олзлов. Чи дайны үйл хэрэгт чадварлаг байсан бөгөөд миний тушаалыг огт зөрчсөнгүй” хэмээн Сяньюньчүүдийн довтолгоог няцаасан талаар тэмдэглэсэн байна.

Бичээсээс үзэхэд, НТӨ 786 онд Сяньюньчүүд Жоугийн Зин-А болон Лихан хэмээх хоёр газарт халдан довтолсон. Вангийн тушаалаар Лай цэргээ удирдан Гүнгү хэмээх газар Сяньюний цэрэг рүү довтолжээ. Лай энэ байлдаанд олон дайсныг алж, олон цэрэг, морь, зэвсэг олзолсон байна. Бичээсийн төгсгөлд, вангийн тушаалыг үнэнчээр сайн биелүүлсэн тул Лайг шагнасан тухай өгүүлдэг. Сяньюнь Жоугийн хооронд болсон энэ байлдааны тухай тэмдэглэл нь Суань ван олон удаагийн цуврал довтолгоо Сяньюний эсрэг хийсэн боловч, түүний хаанчлалын сүүлийн жилүүдэд ч Сяньюньчүүд Жоучуудад аюул учруулсаар байсныг харуулж байна.

Баруун Жоугийн сүүлийн жилүүд буюу Ю (幽You, НТӨ 781-771) вангийн үед, Жунчууд Баруун Жоугийн хил хязгаарыг довтлох нь ширүүсч, Жоугийн умард хилийн хамгаалалтын тогтолцоо бүрэн эвдэгджээ. Цуаньжун нарын довтолгоонд нийслэл хот нь эзлэгдэн, Жоугийн ван алагдсан байна. Баруун Жоугийн засгийн газар аргагүйн эрхэнд Ло (維 Luo) хот руу зугтаан, нийслэлээ шилжүүлснээр Баруун Жоугийн үе төгсөж, Зүүн Жоу буюу Хавар намрын улсын үе эхэлдэг билээ.

Гэвч НТӨ VIII зууны сүүлч VII зууны эхэн үе гэхэд Жунчуудын хүчин бууран доройтож, Зүүн Жоугийн вант улсуудад удаа дараа ялагдах болжээ.

Умард Жунчууд НТӨ 714 онд Жэн (鄭zheng) улс руу, НТӨ 706 онд Ци (齊qi) улс руу довтолсон боловч ялагдсан ажээ²⁴. Ли Жуан гүн (Lu Zhuang gong 魯莊公)-

²³ 劉懷君，劉軍社。陝西眉縣楊家村西周青銅器窖藏。// 考古与文物。2003 年。第 3 期，4，9 頁；商周金文編。陝西出版圖。2009。頁 573-575；

²⁴ 左傳Zuo zhuan. (Legge, The Chinese classics, Vol 5: The Ch'un Ts'ew with the Tso chuen, pp.27- 28, 47, 49)

ийн үе (НТӨ 693-662)-д, Жунгийн эсрэг олон удаа довтолж, тэдэнд хүнд цохилт өгчээ. Эдгээр байлдааны талаарх “Зо Жуань” (左傳zuo zhuan)-ны мэдээ нь:²⁵

十有八年，... 夏，公追戎于濟西。18 дугаар оны намар, гүн Жунчуудыг Зи (濟ji)-ээс баруун тийш хөөв.

二十年，... 冬，齊人伐戎。20 дугаар оны өвөл, Цичүүд (齊人qiren) Жунг довтолов.

二十有四年，... 冬，戎侵曹。曹，羈出奔陳。24 дүгээр оны өвөл, Жунчууд Цао (曹cao)-г эзлэн авч, Цаогийн Кэ Чэнь рүү зугтав.

二十有六年，春，公伐戎。夏，公至自伐戎。秋，公會宋人，齊人，伐徐。26 дугаар оны хавар, гүн Жун руу довтолов. Зун нь гүн Жунгийн довтолгооноос буцаж ирэв. Намар нь гүн Сунчууд (宋人Songren) болон Цичүүд (齊人qiren)-тэй хамтран Сү (徐xu) [жун] руу довтолов.

二十八年，... 又娶二女于戎，大戎狐姬生重耳，小戎子生夷吾，晉伐驪戎，驪戎 男，女以驪姬歸，生奚齊。28 дугаар онд тэрээр Жунгийн хоёр эмэгтэйтэй гэрлэв. Том Жунгийн Хүжи (狐姬huji)-ээс Жун-эр (重耳zhong'er) төрөв. Нөгөө бага Жунгаас И-юй (夷吾yi-yu) төрөв. Зинь (晉Jin) Ли жун (驪戎lirong)-г довтолоход түүний удирдагч түүнд охин Лизи (驪姬lijì)-г өгсөн. Лизи нь Си-ци (奚齊xíqí) хэмээх хөвгүүн төрүүлэв.

三十年，... 齊人伐山戎。30 дугаар онд, Цичүүд (齊人qiren) Уулын жун (山戎shanrong) руу довтолов.

三是有一年，... 六月，齊侯來獻戎捷。31 дүгээр оны 6 сард, Ци-ийн түшмэл ирж, Жунгийн олзлогдогчдыг бэлэвлэв.

“Зо Жуань” (左傳Zuo zhuan)-ы дээрх мэдээнээс үзвэл, НТӨ 674 онд Жунчуудын довтолгоог Жуан гүн (莊公zhuanggong) няцаан баруун зүг мөшгөн хөөжээ. НТӨ 672 онд Ци улс Жунчуудыг довтолжээ. НТӨ 668 онд Жунчууд Цао (Сао曹) улсыг довтолов. НТӨ 666 оны хавар Жуан гүн Жунг довтолсон бол, намар нь Ци улстай хамтран дахин Сыжунг довтолсон байна. НТӨ 664 онд Зинь (晉jin) улсын Сянь (獻xian) Жунчуудыг довтолж, эмэгтэйчүүдийг булаан олзлов. Ци улс Жунгийн эсрэг довтолгоогоо үргэлжлүүлсээр, НТӨ 662 онд Уулын жунд томоохон цохилт өгсөн. НТӨ 661 онд Ци улс Жунчуудыг довлон, олз омог ихтэй иржээ. Ийнхүү “Зо Жуань”-д НТӨ 674-661 оны хооронд Жоучууд Жунгийн эсрэг олон удаагийн цуврал довтолгоон хийн, ялалт байгуулсан талаар өгүүлж байгаа бөгөөд Жунчуудын хүчин бууран доройтсон нь тодорхой байна. Жунчууд бууран

²⁵ 左傳Zuo zhuan. (Legge, The Chinese classics, Vol 5: The Ch'un Ts'ew with the Tso chuen, pp. 96, 99, 106, 110, 113, 117, 118)

доройтож байсан энэ үед Ди нар хүчирхэгжин, тэд мөн Жунчуудыг шахан түрж, газар нутгийг эзлэн авсан гэж судлаачид үздэг. Гэвч Жун бууран доройтсоноор Ди аймгууд орыг эзэлсэн үү, эсвэл ноёлох хэсэг нь өөрчлөгдөн Ди хэмээх болсон уу гэдэг нь тодорхойгүй юм. Ямарч гэсэн хятад сурвалжид нэг хэсэг хугацаанд Жун-Ди хэмээн хамт нэрлэгдэж байснаа аажмаар Жун нэр хэрэглэгдэхээ больж, Ди хэмээх нэрээр тэмдэглэгдэх болжээ.

Гүйфан, Сяньюнь (жун) ба Баруун Жоугийн тэрэгт цэргийн тулаан юу өгүүлнэ вэ?

Кан (康 kang) вангийн 25 дугаар он (979 он)-д цутгасан Сяо Үй дин (小孟鼎 xiao yu ding)-ий хүрэл тогооны бичээсэнд Гүйфаны тэрэгт цэрэгтэй Жоучууд байлдсан үйл явцыг өгүүлж байгаа нь Дотоод Азийн угсаатнууд байлдаанд тэрэгт цэрэг хэрэглэсэн талаарх хамгийн эртний сурвалжийн мэдээ юм. НТӨ 979 онд Жоу болон Гүйфаны хооронд болсон байлдааны ялалтанд зориулан энэхүү бичээсийг тухайн цагт нь цутгасан тул хамгийн итгэж болох сурвалж гэж үзэж болно. Бичээсэнд Жоучууд Гүйфаны цэргийг ялаад, 104+ хэдэн арван морь, 130+ хэдэн арван байлдааны тэрэг, 355+ хэдэн үхэр, 38+ хэдэн хонь олзолсон тухай тодорхой тэмдэглэжээ. Зөвхөн нэгэн удаагийн байлдаанаас 130-аас олон байлдааны тэрэг олзолсноос үзэхэд Гүйфанчууд тэрэгт цэргийг байлдаанд өргөн ашиглаж байсан нь тодорхой байна. Харин НТӨ IX зууны үед Баруун Жоу болон Сяньюний хоорондын дайнд Сяньюньчүүд байлдааны тэрэг хэрэглэж байсныг Дүо Ю дин (多友鼎 duo you ding)-ий бичээс нотолж байна. Дүо Ю диний бичээсэнд Жоу болон Сяньюний хооронд болсон нэгэн удаагийн байлдаанд Жоугийн цэрэг тэдний цэргийг ялж, 127 байлдааны тэрэг олзолсон төдийгүй Янжунд болсон тулаанд Сяньюньчүүд олзлуулахгүйн тулд байлдааны тэргээ шатаасан ба алагдаж, шархатсан морь олон байсан талаар өгүүлдэг.

Тиймээс Дотоод Азийн угсаатнууд адууг тэргэнд хөллөх соёл, байлдааны тэрэг хэрэглэх соёлыг хаанаас авсан бэ? гэдэг асуулт гарч байна.

Дугуйт тэргийг хамгийн анх нээсэн хүмүүс нь Шүмерүүд юм. Тэд дөрвөн дугуйтай нүсэр хүнд тэрэг хэрэглэдэг байсан болохоор тэргэнд үхрийг голлон хөлөлдөг байжээ. Харин Индо-Европууд хэгээст хоёр дугуй бүхий байлдааны тэргийг анх хэрэглэсэн нь цэргийн урлагийн түүхэнд гарсан томоохон амжилт юм. Хэгээс бүхий дугуйтай байлдааны тэрэг (chariot) өмнөд Уралын тал нутгийн Синташта-ын булшнаас олдсон нь хамгийн эртнийх бөгөөд он цагийн хувьд НТӨ

2100 онд холбогдоно²⁶. Хэгээст дугуй нь тэргийг хөнгөн болгож моринд хөллөх боломжтой болж, хурд, маневар сайтай болсноор тэрэгт цэргийг байлдаанд ашиглах болжээ. Индо-Европууд тэрэгт цэргийг байлдаанд анх хэрэглэснээр Евразийн нутагт нэгэн үе давамгайлж, өргөн их тэлэлт, нүүдэл шилжилт хийсэн нь эртний түүхийн хөгжилд томоохон эргэлт болсон билээ. Тэд Ойрхи дорнод, Дундад Азид байлдааны тэрэг хэрэглэх соёлыг нэвтрүүлж, улмаар Шангийн сүүл үе буюу НТӨ 1200-1100 оны үед хятадууд байлдааны тэрэг хэрэглэх болсон ч Жоугийн эхэн үе хүртэл хятадууд байлдааны тэргийг дайнд өргөн хэрэглэж байгаагүй ажээ. Байлдааны тэрэг Евразийн тал нутгаас хэрхэн эртний хятадын нутагт дэлгэрсэн бэ?. Индо-европууд Тэнгэр уулаас зүүн тийш нэвтэрсэн эсэх асуудал ихээхэн маргаантай юм. Сүүлийн үеийн судалгаагаар, Такламаканы цөлөөс европжуу төрхийн эртний хүний “мумми” олдсон нь НТӨ 1800-1200 оны үед холбогдож байна. Харин Тамирын сав нутаг дахь Куча, Карашар, Турфанаас Тохар хэлээрх их хэмжээний материал олдсон нь Тохарын асуудал дэвшигдэхэд хүргэсэн нь нэлээд хожуу буюу НТӨ I мянганы үед холбогдох бололтой. Хятад сурвалжийн мэдээгээр НТӨ III зууны үед, Ганьсугийн нутагт Дуньхуан ба Цилянх уулын хооронд нутаглаж байсан Юэжи нарыг индо-европ хэлтэн байсан гэж үздэг. Индо-европ хэлтнүүдийн нүүдэл Ганьсугаас зүүн тийш нэвтрээгүй болохыг бичгийн сурвалж болон археологи, антроплогийн баримтууд нотолж байна. Өнөөгийн судалгааны түвшинд, Индо-европууд НТӨ II мянганы эхэн хагаст Дорнод Туркестаны нутагт ирж суурьшсан бөгөөд Ганьсугийн коридор нутагт түрэн орж ирсэн нь НТӨ II мянганы сүүл, I мянганы эхэн үед холбогдох бололтой. Монгол нутаг дахь угсаатнууд Алтай болон Дорнод Туркестанд шинээр ирсэн индо-европуудтай НТӨ II мянганы эхэн үеэс харилцаж эхэлжээ. Шан (НТӨ XVI-1045), Баруун Жоу (НТӨ 1045-771) улсууд Төв Шэньси болон Өмнөд Шаньсийн нутаг буюу Шар мөрний доод урсгал, Вэй голын хөндий нутгаас баруунш болон хойш нутгаа тэлж чадаагүй бөгөөд НТӨ II мянганы сүүл I мянганы эхэн үе гэхэд Хэбэй, Хэси, Шаньси, Шэньси, Ганьсугийн бүс нутагт гүйфан, сяньюнь, баруун жун, нохой жун зэрэг угсаатнууд оршин байсан нь сурвалжийн мэдээгээр нотлогдож байна. Иймээс индо-европ хэлтнүүд болон эртний хятадууд хаяа нийлэн, хөршлөн сууж байгаагүй бөгөөд тэдний дунд алтай хэлтэн угсаатнууд оршин байсан нь тодорхой юм. Иймээс алтай хэлтэн угсаатнууд индо-европуудаас байлдааны тэрэг хэрэглэх соёлыг эхлэн авч хэрэглэн, улмаар Шанчууд НТӨ XII

²⁶ Anthony D.W. *The Horses, the Wheel, and Language: How Bronze-age Riders from the Eurasian Steppes Shaped the Modern World*. Princeton University Press, 2007. p. 462, also see 397-405

зууны үеэс байлдааны тэргийг умардын угсаатнуудаар дамжуулан авч хэрэглэх болсон гэж үзэж болно.

Алтай хэлтэн угсаатнууд индо-европуудаас тэрэг, адууг тэргэнд хөллөх соёл, тэрэгт цэргийн байлдааны аргыг авч хэрэглэсэн байна. Адууг тэргэнд хөллөх соёлтой хамт адууг унах соёлыг хамт авсан байх магадлал өндөр юм. Монгол улсын нутгаас хэгээс дугуй бүхий байлдааны тэргийг дүрсэлсэн хадны зураг нэлээд олдоод байгаа нь Монгол нутаг дахь эртний нүүдэлчид байлдааны тэрэг хэрэглэж байсныг давхар баталж байгаагаараа чухал ач холбогдолтой юм. Ийнхүү гүйфан, сяньюньчүүд байлдаанд тэрэгт цэргийг өргөн ашиглаж байсан нь тухайн үед цутгасан хүрэл савны бичээсийн мэдээ болон хадны зургаар батлагдаж байна.

Дотоод Азийн тал нутгийн эртний ард түмний мал аж ахуй, нийгэм, соёлын асуудлыг авч үзэхдээ Хятадын соёлын нөлөөг ихээхэн чухалчилж судалсаар ирсэн. Харин индо-европуудын зүүн тийш хийсэн тэлэлт, тэднээс Дотоод Азийн бүс нутгийн хөгжилд үзүүлсэн нөлөөнд харьцангуй бага анхаарал хандуулж ирсэн билээ. Индо-европ хэлтнүүд зүүн тийш нүүдэллэсээр Дотоод Азийн бүс нутагт “Алтай хэлтэн”-үүдтэй хөршлөн суух болсон. Ийнхүү “Алтай хэлтэн”-үүд индо-европууд болон Хятадуудын дунд оршин, аль алинтай харилцан, соёлын солилцоо хийж, тэдний хооронд соёлын “жуучлагчийн үүрэг” гүйцэтгэж байжээ. Дотоод Азийн нүүдэлчдийн нийгэм, соёлын хөгжилд индо-европуудын үзүүлсэн нөлөө үлэмж их ажээ.

Умардын ард түмнийг нэрлэх эртний хятадуудын нэршлийн асуудал

Хятад сурвалжид монгол нутагт хүрлийн сүүл, төмрийн түрүү үед оршин байсан ард түмнийг яагаад өөр өөр нэрээр нэрлэж тэмдэглэсэн бэ? гэдэг асуудлыг тусгайлан авч үзэх нь чухал юм. Иймээс уламжлалт түүх бичлэгт Шангийн сүүл үед гүйфан, Баруун Жоугийн эхэн үеэс сяньюнь, жун, Зүүн Жоугийн үеэс жун ди, улмаар ди, Байлдаант улсын үеэс ху аймгууд Монгол нутагт оршин байсан хэмээн үздэг билээ. Хятад сурвалжид умардын ард түмний нэрийг өөрчлөн нэрлэдэг хоёр шалтгаан байж болох юм.

1. Умардын овог аймгууд өөрчлөгдөх бүр хятадууд хооронд нь ялган, өөр өөрөөр нэрлэж байсан байж болно. Түүх бичлэгт гүйфан, сяньюнь, жун, ди, ху нарыг хоорондоо холбоогүй, өөр өөр овог аймгууд байсан гэдэг үзэл баримтлал давамгайлж байна. Ингэж тайлбарлах онолын үндэслэл нь умардын угсаатнууд төр ёсны хөгжлийн түвшинд хүрээгүй, овог аймгийн зохион байгуулалттай байсан

тул байнга өөрчлөгдөж, нэг нь нөгөөгөөр солигдож байдаг гэсэн үзэл баримтлал юм. Гэтэл Монгол нутаг дахь эртний нүүдэлчид овог аймгийн нийгэмтэй байсан гэдгийг батлах ямарч баримт байхгүй юм. Харин эртний хятадуудтай хийсэн олон удаагийн дайн, цэргийн зохион байгуулалт, байлдааны стратеги тактикийн давуу тал зэргийг илтгэх сурвалжийн мэдээллээс харахад магадгүй төрийн анхны бүрдлүүд буй болсон байж мэдэх юм.

2. Хятадын династууд умардын ард түмнийг өөр өөрөөр нэрлэж байсан байж болно.

Хятадын династи өөрчлөгдөх бүрт умардын ард түмнийг нэрлэх нэршил өөрчлөгдөж байсан ерөнхий зүй тогтол ажиглагдаж байна. Хятад сурвалжийн мэдээг үндэслэвэл:

-Шангийн үед: Гүйфан

-Баруун Жоугийн үед: Сяньюнь, Жун (баруун жун, нохой жун, уулын жун, сүжун)

-Зүүн Жоугийн үед: Ди (улаан ди, цагаан ди, умард ди)

-Байлдаант улсын үед: Ху (дунху, линху, хүннү г.м) хэмээн нэрлэж байсан ажээ.

Эртний хятадын династи бүр умардын нүүдэлчдийг өөр өөрөөр нэрлэж байсан байж болох юм. Тухайлбал, Баруун Жоугийн үед сяньюнь, жун нэрээр умардын ард түмнүүдийг нэрлэж байсанаа Зүүн Жоугийн эхэн үеэс жун ди нэрийг хослон хэрэглэж байгаад, улмаар жун нэр нь орхигдож, ди нэрийг хэрэглэх болсон нь ажиглагдаж байна.

Түүнчлэн эртний хятад сударчид, умардын ард түмнүүдийг ерөнхий ба оноосон нэрээр нэрлэж тэмдэглэжээ. Тухайлбал, Сяньюнь 獫狁 нь Жоугийн баруун хойно орших угсаатны оноосон нэр, харин Жун гэдэг нь баруун, баруун хойд талын дайсагнасан угсаатныг нэрлэх ерөнхий нэр байсан болохоор зарим тохиолдолд хольж нэрлэх явдал байжээ. Зарим судлаачид Сяньюнь 獫狁 нарыг Жун нартай ойролцоо үед түүхэнд гарч ирж, хятад сурвалжид тэмдэглэгдсэн хэмээн үздэг. Гэтэл Шүлгэлсэн номын “Чүчэ 出車” хэмээх Сяньюньтай хийсэн нэгэн удаагийн байлдааны тухай шүлэгт эхлээд “Сяньюнь 獫狁”-тай дайтаж байгаа талаар өгүүлсэнээ, дараа нь “Баруун Жун 西戎”-тай байлдаж байгаа хэмээн хольж бичсэн²⁷ бол, Дүо Ю дин (多友鼎 duo you ding) бичээсэнд эхлээд Сяньюнь болон Жун нэрийг хольж бичсэн нь энэ хоёр нэрээр нэг угсаатныг нэрлэдэг байсныг харуулж байна. Баруун Жоугийн үеийн хүрэл савны бусад бичээсүүдэд

²⁷ 詩經shijing, (James Legge. The Chinese classics. Vol. 4: The She King. pp. 261-265).

мөн адил Сяньюнь болон Цуаньжун, Сыжун нэрийг сольж бичсэн тохиолдол хэд хэд байна. Тиймээс Сяньюнь бол Баруун Жоу нараас баруун хойно орших угсаатнаа нэрлэдэг оноосон нэр, харин Цуаньжун (нохой жун), Сыжун (баруун жун) нэр нь ерөнхий нэр байсан гэж үзэж болно. Энэ нь Байлдаант улсын үед “Ху” гэж умардын угсаатнуудыг ерөнхийд нь нэрлээд, Хүннү нь түүний доторх нэг улсыг нэрлэсэн оноосон нэр байсан, ху нарыг дунху, линху гэх мэтээр дотор нь ялган нэрэлдэг байсантай адил юм. Эртний хятадын династууд хөрш угсаатнуудаа оршин байгаа зүгээр нь нэрлэдэг ерөнхий нэртэй байсан бөгөөд, тухайлбал, умардын угсаатнуудыг Шангийн үед фан (гүйфан), Баруун Жоугийн үед жун, Зүүн Жоугийн үед ди, Байлдаант улсын үеэс ху хэмээх ерөнхий нэрээр нэрлэж байв. Гэвч умардын угсаатнууд нэгдмэл биш, дотроо олон янз болохоор тэднийг уулын, нохой, баруун, умард, улаан, цагаан гэх мэтээр ялгаж нэрлэхээс гадна, хамгийн хүчирхэг, дайсагнадаг, харилцдаг угсаатнаа оноосон нэрээр бусдаас нь ялган нэрлэж, эртний бичээс, сурвалжуудад тэмдэглэн үлдээжээ. Тийм оноосон нэрээр тэмдэглэгдсэн угсаатны нэг нь Сяньюнь болно.

Шан улсын сүүл үеэс хятад сурвалжид тэмдэглэгдсэн Гүйфанчууд тэрэгт цэрэг бүхий армитай байсан бөгөөд Гүйфанчууд болон Сяньюньчууд (цуаньжун, сыжун)-ын цэрэг, байлдааны тактик маш төстэй байна. Энэ нь хятадууд умардын ард түмнүүдийн талаар бичихдээ үе бүхэнд өөр өөр нэрээр тэмдэглэдэгт үндэслэн умардын ард түмэн өөрчлөгдөж байсан гэж үзэх нь учир дутагдалтай юм. Харин эсрэгээрээ хятад нутагт оршин байсан династи өөрчлөгдөх бүрт сударчид умардын ард түмнийг нэрлэх нэрээ өөрчилж байсан уу гэдэг асуудал гарч байна.

Монгол нутагт оршин байсан овог аймгууд солигдон, өөр өөр аймгууд ээлжлэн оршин байсан учраас эртний хятадууд тэднийг өөр өөр нэрээр сурвалж бичигтээ тэмдэглэн үлдээсэн хэмээх үзэл түүх бичлэгт нэгэнт тогтжээ. Гэтэл эртний хятадуудын Ся, Шан-Инь, Жоу, Байлдаант улс гэсэн нэрний өөрчлөлтийг династийн солигдолттой холбон тайлбарладаг билээ. Эндээс яагаад зэрэгцэн оршиж байсан хоёр ард түмний нэгнийх нь династи солигдох бүрт нэр нь солигддог, нөгөөгийн нэр солигдох бүрт овог аймгууд нь солигддог хэмээн тайлбарлаж байна вэ? гэдэг асуулт гарч байна. Эртний хятадын төр улсын династи солигдох бүрт улсын нэр өөрчлөгдөж байсныг тэдний үлдээсэн түүхэн сурвалжийн мэдээ нотолж байна. Нөгөө талаар онолын хувьд, хятадууд соёлжсон, төрт улс бүхий ард түмэн байсан тул үүнийг хүлээн зөвшөөрч байгаа хэрэг. Тэгвэл монгол нутагт яагаад өөр өөр аймгууд ээлж дараалан оршин байсан хэмээн тайлбарладаг вэ? Үүний

онолын тайлбар амархан бөгөөд хятад сурвалжид умардын ард түмнийг бүдүүлэг, соёлжоогүй “ху” хэмээн тэмдэглэсэн хятад төвт үзэл болон нүүдэлчид өөрийн дотоод хөгжлөөрөө төр байгуулах чадваргүй, “овог аймгийн нийгэм”-тэй байдаг хэмээх өрнөдийн антропологийн онолын үзлээр династиуд биш, овог аймгууд солигдож байсан хэмээн тайлбарладаг байна.

Сяньюньчүүд нүүдэлчид байсан уу?

Хятадын соёлоос эрс ялгарах “Дотоод Азийн соёл” (үүний дотор Монгол нутаг дахь соёл) неолитын үеэс бүрэлдэн буй болж эхэлжээ. Энэ соёлын өвөрмөц байдал буй болоход байгаль газар зүйн нөхцөл, эрхлэх аж ахуйн онцлогоос гадна хүрлийн үеэс эхлэн индо-европуудын соёлын нөлөө ихээхэн чухал үүрэг гүйцэтгэх болсон ажээ. Умардын соёлын онцлог байдал нь тэдний эрхлэх аж ахуйтай салшгүй холбоотой. Дотоод Азийн эртний ард түмнүүдэд мал аж ахуйг ямагт газар тариалангаас илүү чухал үүрэг гүйцэтгэж байсан бололтой. Улмаар хүрлийн үеэс индо-европуудын соёлын нөлөөгөөр нүүдлийн мал аж ахуй үүсч эхэлсэн нь тэдний соёлын онцгой шинж болж байжээ. Гэхдээ нүүдлийн мал аж ахуй давамгайлах аж ахуй болтол нэлээд хугацаа өнгөрсөн бөгөөд төмрийн үеэс л тэдний голлох аж ахуй болсон бололтой.

Гүйфан, сяньюнь, жун-ийн талаарх хятад сурвалжийн мэдээ умардын ард түмнүүд НТӨ I мянганы эхэн үе гэхэд цэрэгт цэргийг байлдаанд өргөн ашиглаж байсныг баталж байна. Түүнчлэн Баруун Жоучууд тэднээс морь, үхэр, хонь олзолж байсан нь тэднийг мал аж ахуй эрхэлж байсныг нотолно.

Эртний хятад сурвалжид тэмдэглэгдсэн гүйфан, сяньюнь, жун, ди зэрэг умардын угсаатнуудыг хятадын (Жоугийн) соёлоос өөр соёлд хамрагдахыг онцолсон ч, тэднийг нүүдэлчид биш, завсрын бүсийн тариачин, малчин ард түмнүүд байсан гэж үздэг.

“Хулсан номын тэмдэглэл”-д үйл явдлыг товч хураангуй тэмдэглэдэг тул Баруун Жоу ба Сяньюнь/Жунчуудтай хийсэн байлдааны үйл явцыг нарийн тэмдэглээгүй, зөвхөн дайнд ялсан, эсвэл ялагдсан тухай мэдээ байдаг. Зарим үед довтолсон гэж тэмдэглэсэн ч байлдаанд ялсан, ялагдсаныг ч дурьдаагүй байдаг. Харин “Лю юэ” зэрэг “Шүлгэлсэн ном”-ын шүлгүүдэд дайны үйл явцын талаар илүү дэлгэрэнгүй өгүүлсэн мэдээлэл байдаг боловч Сяньюнь, Жунчуудын цэргийн талаар мэдээлэл байхгүй юм.

Баруун Жоугийн үеийн Сяо Үй дин (小孟鼎 xiao yu ding), Дүо Ю дин (多友鼎 duo you ding), Гоци Зибай пан (虢季子白盤 Guo jili baipan), Бүцигүй (不其

簋**buqigui**) зэрэг хүрэл савны бичээсүүдэд гүйфан, сяньюнь, жунчууд ба Баруун Жоугийн хооронд болсон байлдааны талаар дэлгэрэнгүй тэмдэглэжээ. Хүрэл савны бичээсийг дайны ялалтыг тэмдэглэн тухайн цаг үед нь цутгасан тул түүхэн үйл явдлыг нотлох ихээхэн үнэ цэнэтэй сурвалжууд юм. Бичээсүүд гүйфан, сяньюнь, жунчууд тэрэгт цэрэгтэй байсныг, Баруун Жоу болон умардын угсаатнуудын хооронд тэрэг цэргийн тулаан болж байсныг нотолж байна. Эдгээр бичээсүүд нь “Хулсан номын тэмдэглэл”, “Го үй”, “Шүлгэлсэн ном”, “Түүхэн тэмдэглэл” зэрэг сурвалжийн мэдээг баталж, тэдгээрийн мэдээллийг өргөтгөж байгаагаараа туйлын чухал ач холбогдолтой юм.

Хятад сурвалж Дотоод Азийн эртний нүүдэлчдийн талаар тэмдэглэсэн цорын ганц бичгийн сурвалж юм. Иймээс умардын эртний нүүдэлчдийн түүх хятад сурвалжаас ихээхэн хамааралтай байдаг. Эдгээр умардын эртний ард түмний тухай хятад сурвалжийн мэдээ ихээхэн бүдэг бадаг байдаг. Харин тэдний нэг болох Сяньюнь болон Жун нартай Баруун Жоу нарын хийсэн байлдааны талаарх мэдээ хятад сурвалжид нэлээд тодорхой тэмдэглэгдэн үлдсэн. Тиймээс Сяньюнь болон Жунчуудын талаарх хятад сурвалжийн мэдээг судлах замаар энэ үеийн умардын ард түмнүүдийн түүхийг тодруулж болох юм.

Сяньюний гарал үүслийн талаар судлаачдын санал нэгдмэл биш байдаг. Ж. Прушек Сяньюнь нарыг нүүдэлчдийн өлгий нутаг болох Төв Азийн Алтай нурууны бүс нутгаас нүүдэллэн ирсэн морьтон дайчид байсан бөгөөд Баруун Жоугийн сүүл үед гэнэт гарч ирж Жоугийн хил хязгаарт довтлох болсон хэмээн үзжээ²⁸. Ж.Прушек Сяньюнь нарыг нүүдэлчид байсан гэдгийн батлахуйц ямар нэгэн баримт дурьдаагүй бөгөөд тэднийг гэнэтийн довтолгоо хийдэг, маневр сайтай, Жоугийн сүүл үед гэнэт гарч ирсэн гэдгийг үндэслэн энэ саналыг дэвшүүлсэн билээ. Гэвч өрнөдийн эрдэмтэд Сяньюнь нарыг нүүдэлчид байсан гэдгийг үгүйсгэдэг бөгөөд эртний хятадууд НТӨ IV зуунаас өмнө нүүдэлчидтэй харилцаж байгаагүй, Байлдаант улсын үеэс анх морьт цэрэг бүхий умардын нүүдэлчдтэй харилцсан хэмээн үздэг. Цинь улсаас өмнөх эртний хятадын сонгодог сурвалжууд болон Хань улсын үеийн төрийн албан ёсны түүхийн мэдээнд үндэслэсэн энэ үзэл баримтлал эдүгээ тогтсон ойлголт болжээ.

Сүүлийн үед археологийн малтлагаар Баруун Жоу улсын үед холбогдох бичээс бүхий хүрэл эдлэл олдсоны дотроос Сяньюнь болон Жунчуудтай хийсэн байлдааны тухай тэмдэглэсэн хэд хэдэн бичээс олдсон нь асуудлыг шинээр эргэн

²⁸ Jaroslav Prushek. *Chinese stateless and the Northern Barbarians in the Period 1400-300 BC*. New York: Humanities Press, 1971, p.130-134.

харах боломжийг олгож байна. Түүнчлэн “Шүлгэлсэн ном”, “Хулсан номын тэмдэглэл” зэрэг Цин улсаас өмнөх сонгодог сурвалжууд болон Хань улсын үеийн “Түүхэн тэмдэглэл” зэрэг төрийн албан түүхийн зарим мэдээг шинээр тайлбарлах боломж олгож байгаа билээ. Судлаачид НТӨ 840 он буюу Ли вангийн 14 дүгээр онд Сяньюнь анх Жоу нарыг довтолсон хэмээн үздэг.

Баруун Жоугийн үеийн хүрэл савны бичээсүүд нь гүйфан, сяньюнь, цуаньжун угсаатнууд нь тэрэг бүхий хүчирхэг армитай, тэд мал аж ахуй эрхэлж байсныг нотолж байна. Дүо Ю дин бичээсэнд өгүүлж байгаагаар, Сяньюнь нар Зингийн цэргийг хүчтэй довтолсон тул ван У гүнд тэдэнтэй байлдахыг тушаасан ажээ. У гүн өөрийн тэрэгт цэргийг удирдан тэдэнтэй байдахыг Дүо Ю-д тушаасан. Энэ байлдаанд Дүо Ю-ийн цэрэг ялж, тэднийг мөрдөн хөөж байлдаж дайсны толгойг авч, баривчилсан төдийгүй Сяньюний тэргийг олзолсон тухай тодорхой өгүүлж²⁹ байна. Энэхүү ялалтыг тэмдэглэн, түүнд зориулан энэ бичээс бүхий хүрэл тогоог цутгасан ажээ. Энэ байлдаан хэдэн онд болсон талаар судлаачдын санал нэгдмэл биш бөгөөд Суань (宣xuan) вангийн үе (НТӨ 827-782), Ли вангийн үе (857/53-842/28) болсон гэдэг дээр судлаачдын санал хуваагддаг. Баруун Жоучуудаас Сяньюний эсрэг хийсэн томоохон довтолгооны нэгний талаар Дүо Ю дин (多友鼎 duo you ding) бичээсэнд өгүүлж байна. Түүнчлэн Гози Зибай пан (虢季子白盤 Guo jili baipan), Бүцигүй (不其簋buqigui) хэмээх хоёр бичээс нь НТӨ 816, 815 онд болсон нэгэн цуврал үйл явдалд зориулан цутгасан гэж зарим судлаачид үздэг.

Дүо Ю дин (多友鼎 duo you ding) бичээсэнд нэгэн удаагийн байлдаанд Жоугийн цэрэг Сяньюний цэргийг ялж, 127 байлдааны тэрэг олзолсон төдийгүй Сяньюньчүүд олзлуулахгүйн тулд байлдааны тэргээ шатаасан ба алагдаж, шархатсан морь олон байсныг өгүүлж байна. Харин Бүцигүй бичээсэнд, нэгэн удаагий тулаанд Жоугийн цэрэг ялж, Бүци цэргээ удирдан Сяньюний цэргийг нэхэн хөөж Сяньюний Гао-инь хэмээх газар довтлон цохиж, Сяньюний олон цэргийг устган, олзолсон байна. Гэнэт Сяньюнь нар олноор цугларч, Жоугийн цэргийн эсрэг гэнэтийн цохилт хийжээ. Хүнд байдлаас амжилттай гарч, тэрэгт цэргийг хохирол багатайгаар авч гарч ирсэн хэмээн Бүци-г сайшаан шагнасан талаар бичээсэнд өгүүлдэг. Бичээсэнд өгүүлж байгаагаас үзэхэд, Сяньюнь нарын цохигдон ухарсан нь байлдааны тактик байсан бөгөөд мөрдөн хөөж байгаа Жоугийн цэрэг урхинд орсон бололтой. Эндээс үзэхэд, Сяньюньчүүд гэнэтийн довтолгоо хийдэг, мөрдөн хөөж байгаа дайсныг отолтон оруулах зэрэг нүүдэлчдийн түгээмэл ашигладаг

²⁹ Shaughnessy, Edward L. “The Date of the Duo You Ding and Its Significance.” *Early China* 9-10. 1983, p.55-69

байлдааны тактикийг хэрэглэдэг, тэрэгт цэрэг бүхий армитай, магадгүй морин цэрэг ашиглаж эхэлсэн байж болох юм. Сяньюний арми тэрэгт цэргээс голчлон бүрдэж байсан нь бичээсээс тодорхой байгаа ч морьт цэрэг ашиглаж эхэлж байсан байж болох юм. Морьт цэрэг монгол нутаг дахь эртний нүүдэлчдийн армийг голлон бүрдүүлж, давамгайлах болсон нь НТӨ V-IV зууны үед холбогдох боловч морьт цэргийн үүсэл нэлээд эрт үед холбогдож болох юм.

Шүлэглэсэн ном (詩經shijing)-д Сяньюнь ба Жоугийн харилцааны тухай дөрвөн шүлгэнд өгүүлжээ. Тэдгээр дууны нэг болох Цай вэй (采薇cai wei) хэмээх шүлгэнд Сяньюний халдлагын эсрэг умард хилийг хамгаалах албанд дайчлагдан, эхнэр нөхөр гэр бүл хагацаж, хүнд алба хаахаар явж байгаа тухай өгүүлжээ³⁰. Чүчэ (出車 chu che) шүлгэнд Сяньюний эсрэг дайнд яваад эргэн ирж байгаа цэрүүдийн тухай өгүүлдэг³¹. Зургаан сар (六月liuyue) хэмээх дуунд Сяньюньтэй хийх байлдаанд вангийн тушаалаар цэрэг дайчлагдан байлдаж байгаа болон Сяньюньчүүд Жоугийн нутагт цөмрөн орж ирж, ширүүн байлдаан Жоугийн нутагт болж байгаа талаар өгүүлжээ³². Цайци (采芣cai qi) хэмээх дуунд Фан Шү жанжин 3000 байлдааны тэрэгт армиа удирдан Сяньюнийг довтолж, энэ дайнд Жоу нар ялсан тухай өгүүлдэг³³. Эдгээр шүлгэнд ачааны болон байлдааны тэргийн тухай онцгойлон өгүүлж байгаа нь тухайн үеийн байлдаанд тэрэгт цэрэг маш чухал үүрэгтэй байсныг харуулж байна. Байлдааны тэргээ унаад тушаал биелүүлж байгаа тухай, бөх бат бөгөөд сайн бэлтгэгдсэн тэрэг цэрэг тулалдааныг хошуучлан байлдаж байгаа тухай өгүүлж байна. Харин Цайци шүлэгт Фан Шү жанжин 3000 байлдааны тэргээ удирдан байлдаанд явж байгаа талаар хэд хэдэн удаа давтан өгүүлж байгаагаас үзэхэд тухайн үед 3000 байлдааны тэрэг гэдэг асар их хүч байсан нь түүний хүчирхэг байдлыг магтан дуулснаас тодорхой харагдах ажээ.

Монгол нутаг дахь угсаатнууд энэ үед газар тариалан, суурин мал аж ахуйгаас нүүдлийн мал аж ахуйд шилжиж байсан бололтой. Тиймээс энэ үед тэд байлдаанд морин цэргийг өргөн ашиглаж байгаагүй ажээ. Морин цэргийг байлдаанд өргөн ашиглаж байгаагүй нь нүүдлийн мал аж ахуй үүсээгүйн баталгаа болж чадахгүй юм. Нүүдлийн мал аж ахуй үүсч, морийг уналга тээвэрт өргөн ашиглаж эхэлсэнээс нэлээд хожим морьт цэрэг үүсч, улмаар аажимдаа цэрэгт цэргийг шахаж, дайнд

³⁰ 詩經shijing, (James Legge. The Chinese classics. Vol. 4: The She King. p. 258-261)

³¹ 詩經shijing, (James Legge. The Chinese classics. Vol. 4: The She King. p. 261-265)

³² 詩經shijing, (James Legge. The Chinese classics. Vol. 4: The She King. p. 281-284)

³³ 詩經shijing, (James Legge. The Chinese classics. Vol. 4: The She King. p. 287)

морин цэрэг гол үүрэг гүйцэтгэсэн болсон байх ёстой. Умардын нүүдэлчдийн армид тэрэгт цэрэг голлох үүрэгтэй байсан үе нь НТӨ I мянганы эхэн үеэс НТӨ V зууны үе гэж үзэж болно. НТӨ I мянганы дунд үеэс морин цэргийг өргөн ашиглаж эхэлсэн бололтой бөгөөд НТӨ IV зуун гэхэд морьт цэрэг давамгайлах болсныг хятад сурвалжийн мэдээ нотолдог билээ. Умардын нүүдэлчдийн армид морьт цэрэг давамгайлж, морин цэргийн тактик хятадын тэрэгт цэргээс илт давуу болж эхэлсэн тэр үеэс Жао Улин ван “харьчуудын хувцас өмсөж, мориноос харваж намнахыг сурсан” болох нь тодорхой юм. Баруун Жоу болон Сяньюний цэрэгт байлдааны тэрэг дайнд гол үүрэгтэй байжээ.

Гүйфан, сяньюнь, олон төрлийн жун, ди (цагаан болон улаан ди), ху болон хүннү, дунху зэрэг умардын олон угсаатны хооронд холбоо хамаарал байна уу, эсвэл тусдаа тусдаа угсаатнууд байсан уу, эрхлэх аж ахуй, соёлын залгамж холбоотой юу гэдэг асуудал нь судлаачдын толгойны өвчин болсон асуудал юм. Нэг хэсэг судлаачид Сыма Цяний үзэл үзлийг баримтлан залгамж холбоотой бөгөөд Хүннүгийн өвөг дээдэс, нүүдэлчид байсан гэж үздэг.

Нөгөө хэсэг судлаачид эдгээр бүдүүлэг аймгууд нь хоорондоо холбоогүй, бутархай аймгууд бөгөөд хэн хүчирхэг болсон нь тухайн үедээ ноёрхож байсан гэсэн санааг дэвшүүлдэг билээ. Энэ саналыг дэвшүүлж буй судлаачид умардын эдгээр аймгийг хятад соёлын бүсэд хамаарагдахгүй боловч, нүүдэлчид биш, голчлон газар тариалан эрхэлдэг суурин иргэд байсан хэмээн үздэг.

Цөөн судлаачид Халоун индо-европ гаралтай гэж батлахыг оролдсон билээ. Харин Ж.Прушек Сяньюнь нарыг Алтай хавиас ирсэн нүүдэлчид байсан байж магадгүй гэсэн саналыг дэвшүүлж, тэд гэнэт гарч ирж Жоучуудыг довтолсон шигээ гэнэт алга болсон гэжээ. Түүнчлэн тэрээр жун, ди нарыг нүүдэлчид байгаагүй, газар тариалан эрхэлдэг суурин хүмүүс байсан хэмээн үзжээ.

Хятадын түүх бичлэгт гэнэт тэмдэглэсэн болохоор судлаачид Сяньюньчүүдийг гэнэт гарч ирсэн буюу аль нэг газраас, тухайлбал, Алтай хавиас нүүдэллэн ирсэн хэмээн саналыг дэвшүүлдэг билээ. Гэтэл Монгол нутаг дахь эртний нүүдэлчид хятадуудтай шууд харилцаж байгаагүй бөгөөд дунд нь завсрын бүсэд янз бүрийн угсаатнууд оршин байсан ажээ. Магадгүй монгол нутагт нүүдлийн мал аж ахуй үүсэж, уг аж ахуйг эрхлэдэг нүүдэлчин угсаатны нэг Сяньюньчүүд урагш нүүдэллэн түрж, хятадуудтай харилцаж эхэлсэн байж болох юм.